

Дүүргийн зөвлөлийн гишүүдээ:

2022-2024 оны санхүүгийн жилийн Амьдрах Орчин Сайжруулах Урьдчилсан Төлөвлөгөөгөө (АОСТ) танилцуулж байгаадаа таатай байна. 2020 оны хавар капиталын хэрэгцээнийхээ талаар сүүлд ярилцах үед КОВИД-19 цар тахал гараад хэдхэн сар болж байсан тул бид нэг жилийн АОСТ-руу даруй шилжсэн билээ. Одоо нэг жилийн дараа бид цар тахлын нийтийн эрүүл мэндийн аюул дуусах тийшээгээ хандаж байгаа хэдий ч хямралын эдийн засгийн нөлөө нь ялангуяа ажлаа алдан сарын түрээсээ төлж чадахгүй байгаа иргэдийн хувьд цаашид үргэлжлэхийг мэдэж байна. Орон байр, хоол хүнс, жижиг бизнесийн дэмжлэг зэрэг манай дүүргийн үндсэн хэрэгцээнд чиглэсэн санхүүгийн ажлууд хийгээд холбооны санхүүжилтийн үйл ажиллагааны төсвийг тэнцвэржүүлэх “гүүр” арга маань дараагийн санхүүгийн жилийг их сорилттой болгож байна.

Цар тахлын дараах амьдралыг холбох гүүр ажлын хүрээнд тодорхой золиос гаргасан билээ. Дүүргийн ажилтнууд дараалан хоёр жил цалин хөлсөө нэмүүлээгүй. АОСТ болон санал хураалтыг сондгой тоотой жилд гаргаж байгаа нь цар тахлын шок байгааг илтгэж байна. Арлингтон Дүүрэг үүнийг сүүлийн хэдэн арван жил хийгээгүй байсан ба гурван жилийн хугацаатайгаар хийгээгүй удаж байна. Гэсэн хэдий ч өнгөрсөн жил тэмдэглэсэнчлэн орлогын огцом уналтын хариуд авах анхдагч арга хэмжээ нь зохицуулалт хийн капиталын хөрөнгө оруулалтыг бууруулах явдал байв.

Энэхүү АОСТ нь шилжилтийн шинж чанартай тул өнгөрсөн жилийн “заавал хийх ёстой” хамгийн наад захын хөрөнгө оруулалтын жагсаалтаас цаашилж байгаа ч хязгаарлалт байсаар байна. Хөрөнгө оруулалтын энгийн зааг хязгаар нь Ерөнхий Санхүүжилтийн төсвийн 10%-иас хэтрэхгүй дүнг өрийн төлөлтөд зарцуулах санхүүгийн бодлого юм. Энэ жил цар тахлаас үүдэн орлого буурахаас гадна зарцуулалтыг танасаар байгаа тул дараагийн хэдэн жилд Ерөнхий Санхүүжилтийн өрийн төлөлтийн хүрээнд тооцоолж буй өсөлтийг хариуд анхдагч арга хэмжээ авах шаардлагатай. Өрийн төлөлтийн өсөлтийг 2023 оны санхүүгийн жилд \$3.7 сая, 2024 оны санхүүгийн жилд \$5.3 сая дотор байлгах нь дараагийн жилийн төсвийн хэлэлцүүлэг, эдийн засгийн сэргэлт хүртэл “гүүр” болж өгөх ба түүнээс хойш 2022 оны хаврын сүүлээс энгийн 10 жилийн АОСТ-рүүгээ эргэн орох боломжтой болох юм.

Санал болгож буй АОСТ нь өнгөрсөн жил боломжтой гэж тооцож тооцож байсан хөрөнгө оруулалтаас илүүг олгоно. Бид Метро зэрэг бүс нутагт хийгдэх чухал төслүүдэд төсөвлөсөн санхүүжилтийг гарган дэд бүтцийн “сайн засвар үйлчилгээ”-ний ажлыг дахин эхлүүлж газар ашиглалт, төлөвлөлт, хөтөлбөрийн хяналтад төсөвлөсөн хөрөнгө мөнгөний урьдчилгаа төлнө. Эдгээр төлөвлөлтийн ажил болон санхүүгийн нөхцөл байдал ирээдүйд сайжирна гэсэн итгэл маань 2022 онд эргэн хэрэгжүүлэх 10 жилийн АОСТ-ын зураглалын эхлэл болно.

Өмнөх төсөвлөлтийг биелүүлэх

Зарцуулалт, капиталын төлөвлөгөөнд орсон шинэ зүйлсэд анхаарал хандуулах хандлага байдаг ч өрийн төлөлтийн хүрээнд төлдөг мөнгийн ихэнхи нь өмнөх жилүүдэд оруулсан хөрөнгө оруулалтын төсвийг хангахад зарцуулагддаг. Дараагийн 12 сард урьд өмнө байгаагүй их шинэ нийтийн барилга байгууламжууд бий болох ба өмнөх шийдвэрүүдийн үр шим харагдаж эхэлнэ:

- Lubber Run Коммюнити Төв – Дүүргийн Зөвлөл нь уг төвийг энэ намар нээхэд шаардлагатай үйл ажиллагаа санхүүжилтийг олгосон. Энэ байран дээр COVID-19-ийн вакцинжуулалтыг хийж байсан болохоор иргэд харсан байгаа. Хөтөлбөрийн төвийн байршил болон цар хүрээ, Төр Хувийн Хэвшлийн Түншлэлийн хүрээнд хийгдэж буй нарны эрчим хүчийн хавтангууд зэрэг нь хэдхэн сарын дараа нээгдэхээр иргэдэд цугларч, чөлөөт цагаа өнгөрөөх гайхалтай орчинг бий болгоно.
- Long Bridge Усан бассейн, фитнесийн газар – Барилга дуусах шатандаа орж байгаа ба Boeing Корпорацийн өгөөмөр хандиваар үйл ажиллагааны зардлыг гаргах болсон тул иргэд, зочид, цэргийн албан хаагчид маань энэ намраас уг байгууламжийг ашиглаж эхлэнэ.
- Гал команд 8 – Дүүргийн Зөвлөл нь Risk гэрээг Барилга угсралтын Менежертэй байгуулсан ба энэ намраас эхлэн энэхүү түүхэн гал командын газрыг дахин барьж эхлэнэ – бүс нутагтаа анхдагч био-нарны эрчим хүчний дээвэр суурилуулна.
- Jennie Dean Парк – арван жил ярилцаж төлөвлөсний эцэст барилгын ажил явагдаж эхэлсэн ба паркийн ахуйн үйлчилгээнүүд 2021 оны эцэс гэхэд нээгдэнэ.

Мөн тээврийн санхүүжилтийн тусгай эх үүсвэр болон муж, холбооноос олгогдох буцалтгүй тусламжаар голчлон санхүүжүүлж буй тээврийн чухал ач холбогдол бүхий олон төслүүд бий.

- ART Үйл ажиллагаа, Засвар үйлчилгээний газар – энэ нь манай автобусны системийн диспетчер, засвар үйлчилгээний нэгдсэн бааз болох ба олон жил ажиллана
- Crystal City Метрогийн Зүүн Орох Цэг – энэ нь Amazon компани ирэхэд зориулсан бүтээн байгуулалттай холбоотойгоор National Landing-д нэвтрэх боломжийг нэмэгдүүлнэ.
- Ballston Баруун Орох Цэг – үүгээр коридор, шинэ дундын давхартай холбогдох хоёр гудамжны түвшингийн шат нэмж орц гарцыг илүү нэмэгдүүлнэ
- Columbia Pike Олон хэлбэрийн зам – энэхүү олон жил хэрэгжих хөтөлбөрөөр явган хүний зам, дугуйн зам, машины зам, транзитийн зам зэрэг тээврийн бүх хэлбэрүүдийг сайжруулна.

Бүс нутагт төсөвлөсөн төсөв

Санал болгож буй АОСТ нь бүс нутгийн Метрогийн системийг санхүүжүүлэхэд дараагийн гурван жилд зарцуулах нийт \$93 долларын үүргийг хангаж байгаа ба ерөнхий үүргийн өрийн бичиг болон мужийн транзитийн тусламжаар санхүүжүүлнэ. Мөн Alexandria хоттой байгуулсан гэрээний хүрээнд Дүүрэг нь тээврийн тусгай фондоос мөнгө гарган West Glebe замын гүүр ба Arlington ridge замын муудсан хоёр гүүрийг \$44 сая доллараар солино. Дүүрэг болон Alexandria хот хамтран Arlington Ridge гүүрийг солих ажлыг Холбооноос олгох тусгай санхүүжилтээр хийхийг зорьж байна.

Сайн засвар үйлчилгээ

Манай Дүүрэг нь дэд бүтэц, технологийн бүх хэсэгт засвар үйлчилгээний хөрөнгийн хөтөлбөртэй ба үүгээр “засвар үйлчилгээг сайтар” хангана. Амьдрах орчинд хөрөнгө оруулах ажлын дээвэр, агааржуулалт, халаалт солих, жим, тоглоомын талбай засах, технологийг шинэчлэх зэрэг нь сэтгэл хөдөлгөм биш ч хамгийн чухал зүйлс юм. Дэд бүтэц хуучирч мууддаг учраас бид сүүлийн 10 жилд санхүүжилтийн ерөнхий түвшинг нэмэгдүүлэх санхүүжилтийн эх үүсвэрт өрийн бичиг, богино хугацааны санхүүжилтийн сонголт (“хэрэгтэй амьдрал” шалгуур үзүүлэлтийг ханган) зэргийг оруулах, орон нутгийн татварын дэмжлэгээс ирдэг санхүүжилтийн илүү уян хатан эх үүсвэр болох явангаа төлөх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэргээр засвар үйлчилгээний хөрөнгийн хөтөлбөрийг тэлж улам сайжруулах ажлыг хийсээр ирлээ. Хамгийн чухал нь бид таван жил тутам нөхцөл байдлын дэлгэрэнгүй үнэлгээ хийж хөрөнгийн ангилал бүрийн жагсаалтыг гаргаж байна. Тус үнэлээг дараа жилийн энэ цаг гэхэд шинэчилсэн байх болно.

Хойшлуулсан засвар үйлчилгээний хөрөнгийн хэрэгцээгээ нөхөх ажилд нэлээн ахиц гаргасан ч цар тахал гарсан болон Amazon компани ирэхийн өмнөх албан газрын сул орон тооны орлогын нөлөөлөлд хариу арга хэмжээ авсанаар эдгээр хөтөлбөрт оруулах хөрөнгө буурсан юм. Энэхүү АОСТ-өөр засвар үйлчилгээний хөрөнгийн хөтөлбөрийг аажмаар эргэн сэргээж эхлэх ба ирэх төсөв, дараагийн 10 жилийн АОСТ-өөнд санхүүжилтийн хүсэлтийг нэмэгдүүлж үйлчилгээг хэвийн явуулах, засвар үйлчилгээ хийгдээгүйгээс дэд бүтцийн томоохон эвдрэл гарахаас зайлсхийх боломжтой болно.

Ус-ариутгах татуурга, борооны усны суваг зэрэг тусгай санхүүжилттэй хөтөлбөрүүд өөрийн засвар үйлчилгээний хөтөлбөртэй байдаг тул Ерөнхий Санхүүжилтийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн засвар үйлчилгээний хөрөнгө оруулалтуудад дараах зүйлс орно.

- *Гүүрний засвар үйлчилгээ:* Alexandria хоттой хамтран хэрэгжүүлж буй гүүрний төслүүдээс гадна уг АОСТ-д \$4.5 сая долларын (паркад байрлаагүй) 25 авто болон 11 явган хүний гүүрний засвар үйлчилгээ багтана. Эдгээр гүүрний дундаж нас нь 48 жил юм.
- *Хатуу хучилт:* Уг АОСТ-д транзит болон дугуйн дэд бүтцэд дэмжлэг болох Дүүргийн 1,061 эгнээ бээр замын хатуу хучилтад засвар үйлчилгээ хийх \$12 сая доллар багтана. Энэ хөрөнгө оруулалт нь хатуу хучилтыг зорилтот 75-80 индексийн хооронд байлгах юм.
- *Технологи:* Дүүргийн богино хугацаат санхүүжилтийн хэрэгслээр голчлон санхүүжүүлэх \$71 сая долларыг гурван жилийн АОСТ-н технологи хөрөнгө оруулалтад оруулсан бөгөөд үүгээр компьютер, сервер, сүлжээний төхөөрөмж, радио системүүдийг засч солино. Хамгийн чухал нь уг АОСТ-д Дүүргийн нас явж буй хүний нөөц, санхүүгийн системийг (PRISM) солих \$14 доллар багтана.
- *Төрийн барилга байгууламжууд:* Санал болгож буй барилга байгууламжийн нийт хөрөнгө оруулалт \$37 сая болох ба үүнд дээвэр, халаатл, агааржуулалтын систем зэрэг засвар үйлчилгээний төслүүд багтана. Засвар үйлчилгээний төслүүдээс гадна 27 жилийн настай Шүүх/Цагдаагийн барилга, шүүхийн ордон, танхим, технологийн суурь дэд бүтэц зэргийг шинэчлэх ажлын дараагийн үе шатны шинэчлэлийн төслүүд багтана. Доор илүү нарийвчлан тайлбарласанчлан үүнд Шүүх/Цагдаагийн барилгын эсрэг талд байрлах 2020 N 14-р гудамжны барилгуудын дэд бүтцийг сайжруулж шинэчлэх хөтөлбөр мөн багтана.
- *Парк:* Уг АОСТ-д засвар үйлчилгээний төслүүдэд голчлон чиглэсэн \$34.3 сая долларын паркийн хөрөнгө оруулалт багтана. Хуучирч буй Bluemont Паркийн теннисийн талбай, зугаалгын газар болон бусад ахуйн үйлчилгээнүүдийг бүрэн шинэчлэх ажил үүнд орсон ба байгалийн нөөц хамгаалах газарт байрладаг тул томоохон шинэчлэл шаардлагатай. Уг АОСТ-д мөн 8-10 жилийн настай нийлэг зүлгийг солих хөрөнгө багтсан. Thomas Jefferson Паркийн дээд өвсөн талбайг нийлэг болгох ажлыг төлөвлөөд байна. Уг АОСТ-өөр Lubber Run дээрх 1 гүүр болон Glencarlyn Паркийн гүүрийг солих зэрэг паркийн жим, гүүрийг сайжруулах хөтөлбөрийг үргэлжлүүлнэ. Эцэст нь энэхүү үе дамнасан төсөл дээр холбооны түншүүд маань сайн анхаарал хандуулж байгаа тул Arlington Завины газрын санхүүжилтийг уг АОСТ-д багтаасан болно.

Ирээдийн Хөрөнгө оруулалтуудыг төлөвлөх нь

Бидний хувьд хамгийн чухал байгууламжуудын засвар үйлчилгээг хангасаар байхын сацуу шинэ төлөвлөгөө гаргах, хуучин төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг нягтлан үзэх ажлыг АОСТ-д оруулсан. Түр АОСТ-н үргэлжлэх хугацаа богино, харин манай төлөвлөгөө, хөтөлбөрүүдийн хугацаа хавьгүй урт тул (зарим тохиолдолд 30-40 жил байна) энэхүү гурван жилийн АОСТ-оор цаашид урт хугацаанд үргэлжлэх төслүүдийн алхамуудыг тавьсан ба хэд хэдэн АОСТ хамрах урт хугацааны төсөвлөлтийг бүрэн хэмжээгээр нь энэхүү түр АОСТ-д тусгаагүй болно. Жишээнүүдээс дурьдвал:

- *Хөршийн Хамгаалалт:* Хөтөлбөртийн хяналт нягталгааг саяхан дуусгасантай холбогдуулан уг АОСТ-д 2021 оны 11-р сарын санал хураалтын \$2 сая долларыг багтаасан \$6 сая долларын ирээдүйн санхүүжилтыг оруулсан. Хөтөлбөрийн хяналтаар санхүүгийн нөхцөл байдлын хүрээнд илүү их хөрөнгө оруулалт хийгдэх шаардлагатай гэж тодорхойлсон.
- *National Landing:* Уг АОСТ-д 2010 онд хэрэгжүүлж эхэлсэн Crystal City Салбарын Төлөвлөгөөний дэмжлэг болох төрөл бүрийн тээвэр, төрийн барилга байгууламж, парк/задгай талбайн сайжруулалт болон саяхан эцэслэн баталсан Pentagon Хотын Төлөвлөлтийн Судалгаа багтсан. National Landing газрын бүтээн байгуулалт нэмэгдэж байгаатай холбогдуулан дараа жилийн хаврын 10 жилийн АОСТ-өөр илүү дэлгэрэнгүйгээр хэлэлцэхэд бэлдэх үүднээс 22202 Амьдрах Боломжийн Санаачилгаас сурсан зүйлд тулгуурлан парк, задгай талбайн төлөвлөгөөг ойрын хугацаанд хянаж үзэх ажлыг ажилтнууддаа даалгасан. Мөн 2024 онд (дүүргийн ашиг тусын төлөөх төсөвлөлтөөр санхүүжсэн) үйлчилгээ хязгаартай номын сан нээгдэнэ.

- *Vision Zero*: Дүүргийн Зөвлөлөөс энэ сард баталсан энэхүү АОСТ-д тээврийн аюулгүй байдлыг дээшлүүлэх дэд бүтцийн элементүүдийг хэрэгжүүлж эхлэх ажлын \$5 сая доллар багтана.
- *Шүүхийн ордон*: Шүүх/Цагдаагийн барилгын дараагийн шатнаас гадна уг АОСТ-д 2020 N 14-р гудамжны барилгын хэсэгчилсэн шинэчлэлийн санхүүжилт багтана. КОВИД-19 цар тахлын үед оффисийн ажилтнуудын ажиллах горимд маш том өөрчлөлтүүд гарсан. Дүүргийн албан газруудын дийлэнхи нь Шүүхийн ордны хэсгийн (Нийгмийн Үйлчилгээний Хэлтсийн гаднах) дөрвөн барилгад байрладаг тул бид утсаар явуулах ажилд зориулан зай талбайг хэрхэн өөрчлөх болон нэгтгэл хийх боломжтой эсэх дээр үнэлгээ хийж эхэлж байна; энэ нь олон жил явагдах ажил юм. Үүний зэрэгцээ бид энэ боломжийг ашиглан хүлээгдэж буй дахин төлөвлөлтийн ажил болон зай талбайг зохицуулах шийдлүүдийг хайж байна. Үүний нэг жишээ бол Clarendon-д зэрэгцээ байрладаг хуучирч буй Дүүргийн Гал Комманд 4 ба Галын Албаны оффисууд юм. Үүнийг 2020 оны барилгаруу шилжүүлсэнээр Clarendon дахь зай талбайг чөлөөлөх боломжтой болно.

2021 оны 11-р сард явуулах санал хураалт

Санал хураалтыг 2021 оны 11-р сард явуулах хүсэлт нь КОВИД-19 цар тахлаас үүдэн хязгаарлагдсан ба зөвхөн нэг жилийн санхүүжүүлэлтийг хамарсан. Ээлжит бус жилд санал хураалт хийх нь нийтлэг биш хэдий ч энэ санал хураалтын хүсэлтээр Метро, хатуу хучилт, парк, дүүргийн барилга байгууламжуудын чухал урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээний төслүүдийн санхүүжилтийн зайлшгүй хэрэгцээг хангах зорилготой юм. Санал хураалтын хүсэлтийн нийт дүн нь \$62.535 сая доллар (Арлингтон Нийтийн Сургуулиуд энэхүү АОСТ-г баталсаны дараа нэмэгдэх тул үүнд ороогүй байгаа) юм.

2021 оны Арлингтон Дүүргийн Өрийн Бичгийн Санал Хураалт	
Дүүргийн дэд бүтэц	17,035,000
Парк, чөлөөт цагаа өнгөрөөх газар	6,800,000
Метро, тээвэр	38,700,000
Дүүргийн санал хураалтын нийт дүн:	62,535,000

Арлингтон Нийтийн Сургуулиуд

Шийдвэрлэх

Арлингтон Нийтийн Сургуулиуд

Арлингтон Нийтийн Сургуулиуд (АНС) нь өөрийн [гурван жилийн АОСТ](#)-г гаргасан ба үүнд \$23.01 сая долларын 2021 оны 11-р сарын санал хураалт орно. Өмнөх үйл ажиллагааны нэгэн адил АНС-н АОСТ болон санал хураалтын хүсэлтийг Сургуулийн Зөвлөл үйл ажиллагаагаа дуусгасны дараа энэхүү АОСТ-д оруулна. Дүүргийн нэгэн адил АНС нь баригдаж буй шинэ Cardinal Бага Сургууль, саяхан баригдаж дууссан Dorothy Hamm Дүнд Сургууль, Fleet Бага Сургууль зэрэг хэд хэдэн томоохон өргөжүүлэлтийн төслүүдийг хийж дуусгасан буюу дуусгаж байгаа юм.

Тээвэр

Уг АОСТ-д (заримыг нь дээр дурьдсан) томоохон олон жилийн төсөл, барилга байгууламжуудаас эхлээд засвар үйлчилгээний хөтөлбөр зэрэг тээврийн сайжруулалтад зориулан (Метроноос гадна) \$710 сая долларыг төсөвлөсөн. Өнгөрсөн жилийн хугацаанд бидний гол анхаарч байсан асуудал бол янз бүрийн стратегийг ашиглан дэд бүтцийн хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийг сайжруулах байсан. Тээврийн төслүүдийн олонхийн хувьд хувийн газраар дамжин өнгөрөх шаардлага гардаг, санхүүжилтийн түншүүдээс олон жилийн санхүүжилт, зөвшөөрөл шаарддаг, бүтээн байгуулалтад том нөлөөтэй байдаг учир нарийн ажиллагаа шаарддаг. Бүрэн санхүүжилт хийгдээгүй байсан ч төслийг зэрэг цааш нь явуулах шинэ аргыг бид санал болгож байна. Дээр дурьдсан шалтгаануудаас үүдэн зарим төслүүдэд хүлээлт үүсэх явдал гарцаагүй гардгийг бодолцон энэ саналыг гаргасан билээ. Энэ аргыг хэрэгжүүлэхийн тулд хөтөлбөрийн түвшинд мөнгөн урсгалын урьдчилсан таамагт 20 хувийн тохируулга оруулна.

Борооны усан суваг

Борооны усан сувгийн хөтөлбөрт оруулах нийт хөрөнгө оруулалт нь энэхүү гурван жилийн АОСТ-н хувьд нийт \$95.9 сая доллар байна. Үүнд \$26.8 сая долларын Spout Run ус цугларах газар, \$16.7 сая долларын Cardinal Бага Сүргүүлийн Борооны ус хуримтлуулах газар, \$5.4 сая долларын Ballston Цөөрмийн ус цугларах газрын сэргээн засварлалт багтана. Дүүргийн борооны усан сувгийн дэд бүтцийг шинэчлэхэд шаардлагатай томоохон ажлуудыг эдгээр хөрөнгө оруулалтуудаар шийднэ. Цаашид хийгдэх томоохон төслүүдэд Donaldson Run цутгалан гол В-н нөхөн сэргээлт, Ballston цөөрөм зэрэг орно.

Дэд бүтэц

Уг АОСТ-р дэд бүтцэд зориулан \$185.2 сая доллар төсөвлөсөн ба үүнд Хатуу Хаягдлын Мастер Төлөвлөгөөний хэрэгжилт, Washington Усан Сувгийн Капиталын \$15.7 сая доллар, Хүндийн Хүчээр дамжуулах хоолойн \$5.7 сая доллар болон Дүүргийн 1,000 орчим бээр урт усан хангамж, ариутгах татуургын шугамнуудыг сайтар засварлах ажлууд багтана. Цаашид хийгдэх томоохон төслүүдэд Fairfax Усан Холбоо, Spout Run Ариутгах Татуургын доторлогоо, South Troу гудамжны Усан хангамж, ариутгах татуургын сайжруулалтын ажлууд орно.

Нийтийн оролцоо

Энэ жил бид АОСТ-ний нийтийн оролцоог биечлэн явуулах боломжгүй байсан хэдий ч онлайнаар ямар ажлыг хийх нь чухал гэдэг дээр 724 оршин суугчдаас санал авсан. Энэхүү АОСТ-р иргэдийн чухал гэж үзсэн олон төслүүдийг бодолцож үзсэн болно. 2023-2032 оны санхүүгийн жилийн АОСТ-г боловсруулахад нийтийн санал сэтгэгдлийг авах болно.

Одоогийн цалин хөлс

Дараагийн хэдэн сард би Мужаас саяхан зөвшөөрөл олгосон төрийн ажлуудын барилгын угсралтын гэрээний цалин хөлсний бодлогын талаар санал танилцуулна. Энэхүү бодлогын санхүүгийн нөлөө нь одоогоор тодорхойгүй байгаа тул энэхүү АОСТ-д оруулаагүй болно.

Захиагаа дуусгахын өмнө би Дүүрэгт чухалчилж үзэх хоёр зүйлийг дурдмаар байна: тэгш байдал ба байгаль орчин. Үйл ажиллагааны төсвийг боловсруулахдаа амьдрах орчингийн хөтөлбөр бүр нь тэгш байдлын санаачилгад хэрхэн тус дэм болох талаар тодорхой яриа өрнүүлсэн. Энэ нь бусад газраас үлгэр жишээ авах боломжгүй нарийн ярвигтай ажил бөгөөд энэ асуудлыг дараагийн АОСТ-уудаар авч үзэх болно. Байгаль орчны хувьд энэхүү АОСТ-нд шинэ төслийн тоо их биш байгаа ч бүх хөтөлбөртөө байгаль орчны зарчмуудыг илүү ихээр оруулсаар байгаа гэж бодож байна. АОСТ-д оруулсан дээвэр солих ажилд нарны эрчим хүчийг ашиглах ба манай дулаан хангамж, агааржуулалтын системүүд нь эрчим хүчинд хэмнэлттэй байна. Мөн бид цахилгаан машин цэнэглэх боломжийг аль болох бодолцож байна. Хийх ажил маш их байгаа ч бидний ажил урагшилсаар байна.

Би Дүүргийн хэлтсүүдийн ажилтнууд, ялангуяа Менежмент, Санхүүгийн Хэлтсийн ажилтнуудад энэхүү богино хугацааны түр АОСТ-г боловсруулсанд нь талархлаа илэрхийлье. Дараагийн хавраас 10 жилийн төлөвлөгөөндөө эргэн орно гэж найдаж байна. Мөн дараагийн хэдэн сард өөрийн саналаа Дүүргийн Зөвлөл болон олон нийтэд танилцуулах болно.

Хүндэтгэсэн,



Марк Ж. Шварц
Дүүргийн Менежер